



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 07 сарын 23 өдөр

Дугаар А/398

Есөнбулаг сум

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2026 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 11 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль, тогтоомж, Засгийн газрын болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх сурталчлан таниулах ажлыг "Миний Алтай" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (М.Насанбат)-т олгосугай.

2. Гэрээний зардалд шаардагдах 19,900,000 (арван есөн сая есөн зуун мянга) төгрөгийг Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (М.Насанбат)-т зөвшөөрсүгэй.

3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулан ажлыг чанартай гүйцэтгүүлэн тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргын Хэвлэлийн алба (Д.Баяраа)-д үүрэг болгосугай.

4. Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж хамтран ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ЧИНБАТ



